# МОНГОЛ УЛС
# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 26 өдөр Дугаар А/189 Номгон

Бууцагаан сумын Байдрагийн гүүр, Галуут сумын Ганцын гүүрэнд хяналтын пост гаргаж ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Засаг даргын 2023 оны А/253, 2024 оны А/27 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын 2024 оны 09 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мал амьтны гоц халдварт "Цэцэг" өвчний халдварын тархалтыг зогсоох, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Онцгой комиссын Шуурхай штабаас Бууцагаан сум дахь Байдрагийн гүүр, Галуут сум дахь Ганцын гүүрэнд хяналтын постыг, дээрх малын гоц халдварт өвчний халдварын тархалтын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан 20 сум тус бүр төв зам дагуу хяналтын постуудыг гаргаж, халдварын голомттой болон эрсдэлтэй бүс нутгуудаар зорчсон иргэд, малчид, тээвэрчдэд ариутгал халдваргүйжүүлэлт хийж, урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл хүргэж, халдварт өвчин тархах эрсдэлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын газар (хурандаа Ж.Алтангэрэл), Цагдаагийн газар (цагдаагийн дэд хурандаа Б.Мөнхбаяр), Хүнс, хөдөө аж ахуйн газар (У.Балжинням), Мал эмнэлгийн газар (Л.Оюун-Эрдэнэ), Байгаль орчин аялал жуулчлалын газар (Э.Ганзориг), сумдын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт үүрэг болгосугай.

2.Хяналтын постод үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хяналтын постод шаардагдах шатахуун, хоол, бичиг хэрэг, түлээ нүүрсний зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлалсугай.

3.Хяналтын пост ажиллуулахад шаардагдах ариутгал халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын хувцас хэрэгслийн зардал болох 24,917,220 (Хорин дөрвөн сая есөн зуун арван долоон мянга хоёр зуун хорин) төгрөгийг аймгийн

62401046

Онцгой комиссын Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн бараа материалын зардлаас, хоол хүнс, түлээ түлшний зардал болох 3,380,000 (Гурван сая гурван зуун наян мянган) төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн мөнгөн хөрөнгийн зардлаас тус тус гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын гамшгийн үеийн удирдлага, зохицуулалт хариуцсан орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын ... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

# МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ГАЛУУТ СУМЫН “ГАНЦЫН ГҮҮР”, БУУЦАГААН СУМЫН “БАЙДРАГИЙН ГҮҮР”-НИЙ ХЯНАЛТЫН ПОСТУУДАД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ АЛБА ХААГЧДЫН ХУВААРЬ

| Д/д | Байгууллага | Нэр | Албан тушаал | 2024 оны 03,04 дүгээр сар | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | III/26 | III/27 | III/28 | III/29 | III/30 | III/31 | IV/01 | IV/02 | IV/03 | IV/04 |
| | | | | | | | | | | | | | |
| 1 | Цагдаагийн газар | а/д Б.Буян-Өлзий | Замын цагдаагийн тасгийн зохицуулагч | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ |
| 2 | Хүнс, хөдөө аж ахуйн газар | М.Алтангэрэл | Мэргэжилтэн | ■ | ■ | ■ | ■ | ■ | | | | | |
| 3 | | Э.Бумбаяр | Мал үржлийн хяналтын улсын байцаагч | | | | | | ■ | ■ | ■ | ■ | ■ |
| 4 | Онцгой байдлын газар | а/ч Б.Нямдорж | ГТУА 16-р ангийн Аврагч, гал сөнөөгч | ■ | ■ | ■ | ■ | ■ | | | | | |
| 5 | | а/а Х.Ганболд | ЭХАБ-ийн Аврагч-усчин | | | | | | ■ | ■ | ■ | ■ | ■ |
| 6 | Байгаль орчин, аялал жуулчлалын газар | Б.Жүгдэржав | Усны асуудал төрийн бус байгууллага хариуцсан мэргэжилтэн | ■ | ■ | ■ | ■ | ■ | | | | | |
| | | Ш.Энхбилэг | Биологийн төрөл зүйл мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн | | | | | | ■ | ■ | ■ | ■ | ■ |
| | | | | | | | | | | | | | |
| 1 | Цагдаагийн газар | а/а Г.Сүхцэрэн | Галуут сумын хэсгийн цагдаа | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ | ■ |
| 2 | Хүнс, хөдөө аж ахуйн газар | М.Балдангомбо | Хүнсний худалдааны хяналтын улсын байцаагч | ■ | ■ | ■ | ■ | ■ | | | | | |
| 3 | | С.Бандихүү | Малын бэлчээр, тэжээл, усан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн | | | | | | ■ | ■ | ■ | ■ | ■ |
| 4 | Онцгой байдлын газар | д/а Б.Болорсүх | ГТУА 72-р ангийн Аврагч, гал сөнөөгч | ■ | ■ | ■ | ■ | ■ | | | | | |
| 5 | | а/ч Г.Түмэнбаяр | ГТУА 72-р ангийн Аврагч, гал сөнөөгч | | | | | | ■ | ■ | ■ | ■ | ■ |
| 6 | Байгаль орчин, аялал жуулчлалын газар | Г.Мөнхсайхан | Галуут сумын Байгаль хамгаалагч | ■ | ■ | ■ | ■ | ■ | | | | | |
| | | С.Бадагаа | Галуут сумын Байгаль хамгаалагч | | | | | | ■ | ■ | ■ | ■ | ■ |

----------oOo---------

Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны
өдрийн А/18 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт

# АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ДОТООДЫН ХАНДИВ ТУСЛАМЖИЙН БАРАА МАТЕРИАЛААС МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ЦЭЦЭГ ӨВЧНИЙ ХЯНАЛТЫН ПОСТОД ЗАРЦУУЛАХ АРИУТГАЛЫН БОДИС, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХУВЦАС, ХЭРЭГСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

| Д/д | Зардлын зүйл | Зориулалт | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Амны хаалт | Аймгийн Онцгой комиссоос Малын гоц халдварт цэцэг өвчний хяналтын постуудад үүрэг гүйцэтгэх алба хаагчдын халдвар хамгааллын хувцас хэрэгсэл | ширхэг | 135 | 1000 | 135,000 |
| 2 | Нэг удаагийн хамгаалалтын малгай | | ширхэг | 1000 | 140 | 140,000 |
| 3 | Нүүрний хаалт | | ширхэг | 100 | 1,500 | 150,000 |
| 4 | Нүдний шил /хамгаалалттай/ | | ширхэг | 109 | 4,000 | 436,000 |
| 5 | Нэг удаагийн халад | | ширхэг | 940 | 6,500 | 6,110,000 |
| 6 | Улавч | | ширхэг | 450 | 200 | 90,000 |
| 7 | Нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл | | ширхэг | 240 | 13,500 | 3,240,000 |
| 8 | Нэг удаагийн бээлий | | ширхэг | 500 | 300 | 150,000 |
| 9 | Нэг удаагийн бээлий | | ширхэг | 9 | 35,000 | 315,000 |
| 10 | Гар ариутгагч | | ширхэг | 10 | 15,400 | 154,000 |
| 11 | Агаар ариутгагч | | ширхэг | 149 | 4,780 | 712,220 |
| 12 | Хөөсөн саван | | ширхэг | 10 | 7,750 | 77,500 |
| 13 | Нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл | Мал эмнэлгийн газарт олгосон халдвар хамгааллын хувцас хэрэгслийн зардал | ширхэг | 500 | 13,500 | 6,750,000 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 14 | Нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл | Зэвсэгт хүчний 339-р ангид олгосон халдвар хамгааллын хувцас хэрэгслийн зардал | ширхэг | 20 | 13,500 | 270,000 |
| 15 | Урьдчилан сэргийлэх эмчилгээний багц | Онцгой байдлын газарт олгосон урьдчилан сэргийлэх эмчилгээний багц | ширхэг | 50 | 20,000 | 1,000,000 |
| 16 | Жавелон | Аймгийн Онцгой комиссоос Малын гоц халдварт цэцэг өвчний хяналтын постод хийх ариутгалын халдваргүйтгэлийн зардал | ширхэг | 20 | 85,000 | 1,700,000 |
| 17 | Спирт 5л | | ширхэг | 6 | 100,000 | 600,000 |
| 18 | Гипохлорт кальци | | ширхэг | 525 | 5,500 | 2,887,500 |
| Нийт дүн | | | | | | **24,917,220** |

## АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХЯНАЛТЫН ПОСТОД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ АЛБА ХААГЧДЫН ХООЛ, ТҮЛЭЭ НҮҮРСНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Зардлын зүйл | Зориулалт | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | **2** | **3** | **4** | **5** | **6** | **7** |
| 1 | Мах | Аймгийн Онцгой комиссоос Малын гоц халдварт цэцэг өвчний 2 хяналтын постуудад үүрэг гүйцэтгэх 10 алба хаагчдын 10 хоног ажиллахад шаардагдах хоол, түлээ нүүрсний зардал | Килограмм | 130 | 13,500 | 1,755,000 |
| 2 | Гурил | | Килограмм | 75 | 2,200 | 165,000 |
| 3 | Будаа | | Килограмм | 80 | 4,000 | 320,000 |
| 4 | Гоймон | | Килограмм | 50 | 4,000 | 200,000 |
| 5 | Төмс | | Килограмм | 40 | 1,500 | 60,000 |
| 6 | Лууван | | Килограмм | 44 | 2,500 | 110,000 |
| 7 | Манжин | | Килограмм | 44 | 2,500 | 110,000 |
| 8 | Сонгино | | Килограмм | 40 | 3,000 | 120,000 |
| 9 | Ургамлын тос | | Ширхэг | 20 | 7,500 | 150,000 |
| 10 | Давс | | Ширхэг | 4 | 2,500 | 10,000 |
| 11 | Түлээний мод | | Ширхэг | 10 | 8000 | 80,000 |
| 12 | Нүүрс (Том шуудайтай) | | Шуудай | 30 | 10,000 | 300,000 |
| **Нийт дүн** | | | | | | **3,380,000** |

----------oOo---------